



ЭРҮҮЛ МЭНДИЙН
ХӨГЖЛИЙН ТӨВ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

НЭЭЛТТЭЙ АЖЛЫН БАЙРНЫ ЗАР

Захиргаа, санхүү, удирдлагын албанд **Төлөвлөлт, тайлагналт хариуцсан мэргэжилтний** ажлын байрны сонгон шалгаруулалтад оролцохыг урьж байна.

Гүйцэтгэх үүрэг:

- Төвийн стратеги, гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлан нэгтгэх, төлөвлөлт, тайлагнах үйл ажиллагааг мэргэжил, арга зүйгээр хангах;
- Төвийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцад хяналт тавих, мэргэжил, арга зүйгээр хангах, тайлагнах, мэдээллээр хангах;
- Байгууллага, албаны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.

Тавигдах шаардлага:

- Менежмент ба удирдахуй, Маркетинг, Эрх зүй, Хүний нөөцийн удирдлага, Анагаах ухаан, Нийгмийн эрүүл мэндийн бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй;
- Төлөвлөлт, тайлагналтын чиглэлээр сургалтад хамрагдсан байх;
- Мэргэжлээрээ ажиллаж байсан туршлагатай;
- Мэдээлэл цуглуулах, гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах;
- Дүн шинжилгээ хийх, асуудал шийдвэрлэх, багаар ажиллах ур чадвартай байх;
- Энэ чиглэлээр цаашид тогтвор суурьшилтай ажиллах хүсэлтэй байх;
- Шударга, ёс зүйтэй, зарчимч байх;
- Эерэг харилцаа, хандлагатай байх.

Бүрдүүлэх материал:

- Төрийн албан хаагчийн анкет;
- Их дээд сургууль төгссөн мэргэжлийн дипломын хуулбар (нотариатаар баталгаажуулах);
- Мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдсан бол гэрчилгээний хуулбар;
- Нийгмийн даатгал төлсөн лавлагаа;
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Ажилд орохыг хүссэн өргөдөл.

Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй иргэдийн материалыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (Сүхбаатар Дүүрэг, 1-р хороо, Энхтайвны гудамж-13Б)-ийн төв байр, 2 давхар, 203 тоот өрөөнд 2024 оны 5-р сарын 15-ны өдөр хүртэл хугацаанд хүлээн авна.

Утас: 70128805

ЗАХИРГАА, САНХҮҮ, УДИРДЛАГЫН АЛБА

2024.04.17